



ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалт
/УАГ-НАГ/2016/НА-01

ОНХС-аар хэрэгжүүлжсэн төсөл арга хэмжээний гүйцэтгэлд
тавих хяналт шаардлага хангахгүй, ажлын гүйцэтгэлийг хянаж
баталгаажуулалгүй санхүүжилтийг олгож байна.

2016 он

Аудитын тайлан, дүгнэлттэй
холбоотой асуудлаар нэмж
газар
тодруулах, асууж лавлах зүйл
байвал 70463783, 70463612
дугаарын утсаар харилцана уу

ХАЯГ:
Завхан аймгийн Аудитын

Улиастай сум, Жинст багийн
Нутгийн захиргааны ордон
309,310 тоот өрөө

Гүйцэтгэсэн :

Ахлах аудитор
Д.Оюунжаргал
Аудитор
Ч.Бямбасүрэн
Б.Жалбаа

Хянасан:

Дарга, Тэргүүлэх
аудитор Х.Болдбаатар

Аудитын менежер
Б.Дагвасүрэн

2016.04.29

АГУУЛГА

Нэг. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг хууль, журамд заасан нэр төрлөөр нь бодитой төлөвлөж бүрдүүлж чадаагүй байна.

- 1.1 Орон нутгийн хөгжлийн сангийн орлогыг хууль журамд заасан нэр төрлөөр нь төлөвлөөгүй байна.
- 1.2 Аймаг нэгдсэн сангаас олгосон шилжүүлэгийг хуваарилахдаа холбогдох журмыг баримталсан байна.
- 1.3 Аймаг болон сумын ЗДТГ нь ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг орон нутгийн бодлого чиглэлтэй уялдуулан иргэдээр хэлэлцүүлэн санал авсан байна.
- 1.4 ОНХС-ийн төлөвлөгөөнд ТЭЗҮ хийгдсэн, зураг төсөв нь батлагдсан, төсөвт өртийг урьдчилан тооцсон хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээг тусгахгүй байна.
- 1.5 Аймгийн Засаг дарга сумдын ОНХС-ийн төлөвлөгөөнд өөрчлөлт оруулсан зөрчил байна.

Хоёр. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг хууль, журамд заасны дагуу бүрдүүлж зарцуулаагүй байна.

- 2.1 Гадаад тусламжийн орлогыг ОНХС-д төвлөрүүлэлгүй зарцуулжээ.
- 2.2 ОНХС-аар хэрэгжүүлжсэн төсөл арга хэмжээний гүйцэтгэлд тавих хяналт шаардлага хангахгүй, ажлын гүйцэтгэлийг хянаж баталгаажуулалгүй санхүүжилтийг олгож байна.
- 2.3 Сангийн хөрөнгөөр нийлүүдэгдсэн тоног төхөөрөмжүүдийг данс бүртгэлд бүрэн тусгаагүй байна

Гурав. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулж, олон нийтэд ил тод мэдээлээгүй байна.

- 3.1 ОНХС-ийн хөрөнгийн төлөвлөлт, хэрэгжилтийн байдалд тавих хяналт хангалтгүй байна.
- 3.2 Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг байршуулан ажилласан байна
- 3.3 Өмнөх оны аудитаар өгөгдсөн акт, албан шаардлага, зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй байна

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
БИНХ	Багийн иргэдийн нийтийн хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
АБОУС	Аудитын байгууллагын олон улсын стандарт
ҮАГ	Үндэсний аудитын газар
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ЭЗ	Эдийн засаг
ТЭЗҮ	Техник, эдийн засгийн үндэслэл
СС	Сангийн сайд
ЗГ	Засгийн газар
ТБОНӨХБАҮХАТ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай
НАНБХАСЗАСЗУСТ	Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхолыг зохицуулах, ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, бэрхшээл

Аудит хийх үндэслэл бүрэн эрх:

Аудитыг Монгол Улсын Их хурлын Төсвийн байнгын хорооны 2016 оны “Аудитын сэдэв батлах тухай” 01 дүгээр тогтоол, Монгол Улсын Ерөнхий Аудиторт УАГ-аас 2016 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон төрийн аудитын төрөлжсөн болон орон нутаг дахь салбар байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

Аудитын зорилт:

ОНХС-ийн 2015 оны хөрөнгийн төлөвлөлт, орлого бүрдүүлэлт, зарцуулалт, түүнд тавих хяналтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулсан эсэхэд аудит хийж, гарсан зөрчлийг арилгах, цаашид сайжруулах, санал, зөвлөмж боловсруулан холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх, аудитын дүнг УИХ-д танилцуулахад аудитын зорилт чиглэгдлээ.

Дээрхи зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтуудын дагуу аудитыг хийлээ.

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг хууль, журамд заасны дагуу төлөвлөж, хуваарилсан эсэх
2. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг хууль, журамд заасны дагуу бүрдүүлж, зарцуулсан эсэх
3. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулж, олон нийтэд ил тод мэдээлсэн эсэх

Аудитын хамрах хүрээ:

- ❖ Орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлүүд
- ❖ Засаг даргын мөрийн хөтөлбөр, ЭЗ, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл
- ❖ Аймгийн ИТХ-ын тогтоол
- ❖ Сумдын ИТХ-ын тогтоол
- ❖ ИТХ, БИНХ-ын протоколууд
- ❖ Худалдан авах ажиллагаа
- ❖ Засаг даргын захирамжууд
- ❖ Үнэлгээний хорооны шийдвэрүүд
- ❖ Захиалагч, гүйцэтгэгчийн хооронд байгуулсан гэрээнүүд
- ❖ ИТХ-ийн дэргэдэх хяналтын хорооны хяналт шалгалтын материалууд
- ❖ Ажлын санхүүжилтийн хуваарь, ОНХС-ийн дансны хуулга
- ❖ Төсөл арга хэмжээг хүлээж авах, ашиглалтанд оруулах акт
- ❖ Хөндлөнгийн хяналт шалгалтын материалууд
- ❖ Төсөл арга хэмжээний ТЭЗҮ-үүд, зураг төсөв

- ❖ ОНХС-ийн хэрэгжилтийн тайлан мэдээ
- ❖ Төсөл арга хэмжээний мэдээллийн сан
- ❖ Хөрөнгийн бүртгэл, хамгаалалт
- ❖ Шилэн дансны цахим мэдээллийн сан
- ❖ Холбогдох албан тушаалтангууд
- ❖ Бусад

Үндсэн үйл ажиллагааны үндсэн чиг үүрэг, зорилго

ОНХС-ийн зорилго нь орон нутгийн хөгжлийг дэмжих, бүс нутгийн тогтвортой байдлыг хангасны үндсэн дээр иргэдийн тогтвор сууьшилтай амьдрах орчин бүрдүүлэхэд чиглэгддэг.

Үндсэн мэдээлэл:

Аймгийн ИТХ-ын 2015 оны 04 сарын 30-ны 52 дугаар тогтоолоор Сумдын орон нутгийн хөгжлийн санд олгох шилжүүлгийг 2896.6 сая төгрөгөөр, Аймгийн ОНХС-д олгох шилжүүлгийг 1929.8 сая төгрөгөөр баталжээ.

Гүйцэтгэлээр сумдад 2246.5 сая төгрөг, Аймгийн ОНХС-д 1760.3 сая төгрөг, нийт 4006.8 сая төгрөгийг тус тус хуваарилжээ.

Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэхдээ АДБОУС 100-400, 4200, Төрийн хяналт шалгалтын стандарт, нийцлийн аудитын журам, төлөвлөгөө хөтөлбөрийн дагуу дэд хөтөлбөр боловсруулан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа болон судалгаа авах, орлогын бүрдүүлэлт, зарцуулалтын нөхцөл байдал, үр дүнд шинжилгээ хийх, шалгаагдагч байгууллагаас авсан мэдээлэл, нотлох зүйлсийг нягтлан шалгах, тулган баталгаажуулах, анхны баримтаас хөөн шалгах, давтан гүйцэтгэх, бодит байдал дээр оршин байгааг үзэх, харьцуулах, нэгтгэх, зэрэг аудитын горимын дагуу аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсруулан ажиллаа.

Аудит хийж буй асуудлыг нэгтгэж тайланд тусгахдаа дараах арга зүйг ашиглаж баримтжууллаа.

- ОНХС-ийн хөрөнгийг хуваарилахдаа сум дүүргийн хөгжлийн индексийг үнэн зөв тооцсон эсэх
- БИНХ-ын тэмдэглэл, иргэдийн санал асуулгын хуудас хурлын шийдвэртэй нийцсэн эсэх
- БИНХ-аас гарсан шийдвэр тухайн шатны ЗДТГ, ИТХ-ын шийдвэртэй нийцэж байгаа эсэх
- Тухайн шатны ЗДТГ, ИТХ-ийн шийдвэр нь орон нутгийн хөгжлийн бодлого, ОНХС-ийн журамтай нийцэж байгаа эсэх

- Худалдан авах үйл ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулсан эсэх
- ОНХС-ийн дансны хуулга ажлын санхүүжилтийн хуваарь, гэрээний дүнтэй тохирч байгаа эсэх
- Төсөл арга хэмжээний гэрээг батлагдсан гэрээний загварын дагуу байгуулсан эсэх
- Сангийн хөрөнгийг Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан журамд тусгагдсан чиг үүргийн дагуу зарцуулсан эсэх
- ТЭҮЗ нь бодит гүйцэтгэлтэй нийцэж байгаа эсэх
- Гэрээний хугацаанд хийгдээгүй ажлуудад алданги тооцож, хяналт тавьж ажилласан эсэх
- Төсөл арга хэмжээнд заасан ажлыг газар дээр нь очин үзэж, зураг төсөвтэй харьцуулан судалж, зураг авалт, ажиглалт хийсэн
- Хөрөнгө оруулалтын ажлыг ашиглалтанд хүлээн авсан комиссын актыг бодит байдалтай тулган, данс бүртгэлд тусгасан эсэхийг тулган баталгаажуулсан
- Иргэдээс санал асуулга авсан
- Өмнөх аудитаар өгөгдсөн шийдвэрийн хэрэгжилтийг тулган шалгасан
- Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг үзсэн

Аудитын стандартын талаархи мэдэгдэл

Аудит дараах хууль эрхийн актыг шалгуур үзүүлэлт болгоно.

- Төрийн аудитын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- 2015 оны төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- ТБОНӨХБАҮХАТ хууль
- НАНБХАСЗАСЗУСТ хууль
- Засгийн газрын 2012 оны 30 дугаар тогтоол /ОНХНС болон ОНХС-аас олгох шилжүүлэг тооцох аргачлал/
- Засгийн газрын 2013 оны 68 дугаар тогтоол /Босго үнэ батлах тухай/
- Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаал /Заавар батлах тухай/
- Сангийн сайдын 2013 оны 39 дугаар тушаал /журам, жишиг өаримт бичиг батлах тухай/
- Сангийн сайдын 2012 оны 290 дугаар тушаал / журам шинэчлэн батлах тухай/
- Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаал /ОНХС-ийн заавар/
- Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаал /Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам/
- Засгийн газрын 2012 оны 17 дугаар тогтоолоор батлагдсан “Төсөв санхүүгийн ил тод байдлыг хангахад дагаж мөрдөх журам”

- Төлбөрийн акт, албан шаардлага өгөхөд баримтлах журам
- Сангийн сайдын 2015 оны 4/6353 албан тоот

Аудит хийх багийн бүрэлдэхүүн

Аудитыг Аймгийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар удирдаж, аудитын менежер Б.Дагвасүрэн чанарын хяналтыг хэрэгжүүлэн, Ахлах аудитор Д.Оюунжаргал үе шатны хяналт тавьж, аудитор Б.Жалбаа, Ч.Бямбасүрэн нар төлөвлөгөө хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэлээ.

Аудитын хугацаа

Аудитыг 2016 оны 1 дүгээр сарын 18-наас эхэлж, 4 дүгээр сарын 19-нд аудитын менежерийн хяналтанд өгч, тэргүүлэх аудиторроор хянан баталгаажуулан 2016 оны 05 сарын 01-ны дотор ҮАГ-ын нийцлийн аудитын газарт хүргүүлсэн.

Аудитын тайлангийн бүтэц, түүнд тусгагдах мэдээлэл, хэлэлцүүлэх журам

Аудитын тайлан нь оршил хэсэг, аудитын дүн, дүгнэлт, холбогдох байгууллагын санал, аудитын зөвлөмж, албан шаардлага, акт болон тайлангийн хавсралт хэсгүүдээс бүрдэнэ.

Аудитын тайланд аудитын зорилтууд болох дээр дурьдсан 3 асуултанд хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох зүйлс, мэдээллийг хангалттай хэмжээгээр оруулж өгнө.

Аудитын тайланг шалгаагдагч байгууллагын удирдлага, хамт олон, холбогдох албан тушаалтангуудад танилцуулж, санал авч, аудитын тайланг эцсийн хувилбараар боловсруулан удирдлагын зөвлөлөөр хэлэлцүүлэн батлууллаа.

Аудит хийхэд учирсан бэрхшээл

- ❖ Санхүүгийн тайлангийн аудиттай хугацааны хувьд давхацсан тул цаг хугацаа хязгаарлагдмал байсан. Тайлант онд нийт 315 байгууллагын санхүүгийн тайланд баталгаажуулах аудитыг хийхэд хүн хүчний хүрэлцээгүйгээс тус аудит хугацаа хоцорч эхэлсэн.
- ❖ ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн ажлуудыг бодит байдал дээр нь очиж үзэхэд хугацаа их алдсан. Учир нь аудит хийх хугацаанд сумдаар цас их хэмжээгээр орж зам даваа хаагдаж, хөдөө сумдад томилолтоор ажиллахад бэрхшээл тулгарсан.

Зорилт 1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг хууль, журамд заасан нэр төрлөөр нь бодитой төлөвлөж бүрдүүлж чадаагүй байна.

1.1 Аймгийн 2015 оны төсвийн төсөлд Орон нутгийн хөгжлийн сангийн орлогыг хууль журамд заасан нэр төрлөөр нь төлөвлөөгүй байна.

ОНХНС-аас аймгийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийн төлөвлөлт тооцооллыг Сангийн яам хийдэг байна.

ТЕЗ-гаас Сангийн яаманд хүргүүлсэн “Аймгийн 2015 оны төсвийн төсөл”-д ОНХС-гийн орлогын талаарх саналыг тусгаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 27.1.7 дахь заалт **/орлого, зарлагыг дотоод гүйлгээнээс бусад нийт гүйлгээний дүнгээр төлөвлөж, бүртгэж, тайлагнах/-ыг мөрдөж ажиллаагүйтэй холбоотой байна.**

Идэр, Их-уул, Баянтэс, Алдархаан зэрэг сумд орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрийг хууль журамд заасан нэр төрөл тус бүрээр тооцон төсвийн төслөө боловсруулсан хэдий ч аймгийн төсвийн төсөлд тусгагдаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 27.1.7 **/орлого, зарлагыг дотоод гүйлгээнээс бусад нийт гүйлгээний дүнгээр төлөвлөж, бүртгэж, тайлагнах/**, Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журмын 6 дүгаар зүйлийн 6,1 **/Аймаг, нийслэлийн Засаг дарга орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлэг тооцох аргачлалыг ашиглан тухайн шатны орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрийг дараах байдлаар тооцож төлөвлөнө/**, 6.2 **/Сум, дүүргийн Засаг дарга орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрийг дараах байдлаар тооцож төлөвлөнө/** гэсэн заалтуудыг тус тус зөрчиж байна.

1.2 Аймаг нэгдсэн сангаас олгосон шилжүүлэгийг хуваарилахдаа холбогдох журмыг баримталсан байна.

Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас аймгийн орон нутгийн хөгжлийн санд 7714.2 сая төгрөгийг олгохоор батлагдсан байна.

Сангийн яам ОНХС-гийн төсөвт тодотгол хийснээр аймаг ОНХС-гийн төсвийг дахин тодотгон 4841.0 сая төгрөгийн санхүүжилт авахаар төлөвлөсөн боловч 4006.8 сая төгрөгийг авсан нь тодотгосон төсвөөс 82.76 хувийг олгосон байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалт

Нэгдсэн сангаас олгох шилжүүлэгийг аймаг, сумын ОНХС-д Төсвийн тухай хуулийн 59.2 дахь заалт, 59.3 дахь заалт, Засгийн газрын 30 дугаар тогтоолын дагуу тооцож хуваарилсан байна.

1.3 Аймаг болон сумын ЗДТГ нь ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг орон нутгийн бодлого чиглэлтэй уялдуулан иргэдээр хэлэлцүүлэн санал авсан байна.

ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэхээр төлөвлөсөн ажлууд нь Орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдсан байна.

Сумд ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөхдөө иргэдээс санал авсан байна.

Аймгийн Засаг дарга ОНХС-ын хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төслийн урьдчилсан жагсаалтыг гарган баг, хорооны хурал, иргэний танхимаар хэлэлцүүлэн санал авсан байна.

Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар батлагдсан Орон нутгийг төсвийн төсөл боловсруулах журмын 12 дугаар зүйлийн 12.1.1 /аймгийн Засаг дарга тухайн шатны ОНХС-гийн хөрөнгөөр тухайн жилд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр төсөл арга хэмжээний төлөвлөгөөний урьдчилсан жагсаалтыг боловсруулж жил бүрийн 3 дугаар улиралд багтаан иргэд олон нийтийн саналын авна/ гэсэн заалтыг хэрэгжүүлэн ажилласан байна.

Аймгийн засаг дарга ОНХС-аас хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалтыг хууль тогтоомжинд тавьсан шаардлагын дагуу төлөвлөгөөнд тусгасан байна.

1.4 ОНХС-ийн төлөвлөгөөнд ТЭЗҮ хийгдсэн, зураг төсөв нь батлагдсан, төсөвт өртийг урьдчилан тооцсон хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээг тусгахгүй байна.

Аймаг ОНХС-гийн эх үүсвэрээр 34 төрлийн ажлыг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Үүнээс 3 нь батлагдсан зураг төсөвгүй, техник, эдийн засгийн үндэслэл хийгдээгүй ажил байна.

Аймгийн ОНХСанд батлагдсан зураг төсөвгүй тусгагдсан ажил

Сая төгрөг

Д/Д	Төсөл арга нэмжээний нэр				Төсөвт өртөг	Санхүүжүүлсэн дүн
1	Эрх	шилжүүлэн	хэрэгжүүлсэн	Шилүүстэй	12,0	12,0

Орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалт

	сумын 160 суудалтай сургуулийн хичээлийн байрын тохижилт		
2	Эрх шилжүүлэн хэрэгжүүлсэн Ургамал сумын 160 суудалтай сургуулийн хичээлийн байрын тохижилт	12,0	12,0
3	Хилийн бүсд нийтийн халуун ус барьж тохижуулах	12,0	12,0

Сумдын ОНХС-ийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудын ТЭЗҮ-ийг ИТХ-аар жагсаалт хэлэлцэн баталсаны дараа гаргаж, байгаа нийтлэг дутагдал байна.

Төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудаас аймагт худалдан авах ажиллагаа нь зохион байгуулагдсан төсөл арга хэмжээний төсвийг холбогдох мэргэжлийн байгууллагуудаар хийлгэсэн байна.

Сумдад хэрэгжүүлэх ажлуудын төсөвт өртгийг Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4 /Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана/, Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан “ОНХС-ийн заавар”-ын 4.7 “ Хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээ нь хуульд заасны дагуу ТЭЗҮ хийгдсэн, зураг төсөв нь батлагдсан, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийгдсэн, бусад зөвшөөрөлтэй байх” гэснийг зөрчин урьдчилан тооцолгүй, баримжаагаар өртгийг тогтоодог, хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл арга хэмжээ хэт жижгэрсэн, хөрөнгө бэлтгэж байгаа дутагдал жил бүр давтагдан гарч байна.

1.5 Аймгийн Засаг дарга сумдын ОНХС-ийн төлөвлөгөөнд өөрчлөлт оруулсан зөрчил байна.

Аудитын явцад ИТХ-ын тогтоол шийдвэр, хуралдааны хурлын тэмдэглэл зэрэгтэй танилцан удирдлагуудтай уулзалт хийн тайлбар тодруулга авч, харилцан ярилцлага хийхэд ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжих хөрөнгө оруулалтыг иргэдийн амьдралд хэрхэн нөлөөлөх, гарах үр дүн зэргийг хэлэлцэн баталсан байна гэж үзэх үндэслэлтэй байна.

Аймгийн Засаг даргын албан бичгээр сумдын ОНХС-ийн төлөвлөгөөг өөрчлүүлэн багийн ИНХ-аар дэмжигдээгүй ажлыг санхүүжүүлсэн нь ОНХС-ийн заавар, журмын 6.3.4 /орон нутгийн дунд хугацааны төлөвлөгөөтэй уялдуулсан байх/, 6.3.5 /иргэдийн оролцоог хангасан байх/ гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн дараах төсөл арга хэмжээг хэрэгжүүлсэн дутагдал байна. Үүнд:

- ❖ Онцгой байдлын тоног төхөөрөмж бэлтгэх ажилд 10 суманд 54.4 сая төгрөгийн
- ❖ Цаг уурын хамгаалалтын сүлжмэл торон хашаа болон засварын ажлуудад 10 суманд 10.8 сая төгрөгийн ажлыг хэрэгжүүлэхээр тусгуулсан байна.

Зорилт 2. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг хууль, журамд заасны дагуу бүрдүүлж зарцуулаагүй байна.

2.1 Гадаад тусламжийн орлогыг ОНХС-д төвлөрүүлэлгүй зарцуулжээ.

Орон нутгийн давсан орлогоос аймаг 90.0 сая төгрөгийг, нэр бүхий 12 сум 250.0 сая төгрөгийг, бусад эх үүсвэрээс 15.2 сая төгрөгийг журмын дагуу тус тус ОНХС-ийн дансанд төвлөрүүлэн ажилласан байна.

Аймаг болон сумд татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх замаар бий болсон эх үүсвэр байхгүй байна

Мөн зардлыг хэмнэж бий болгосон орлогын эх үүсвэр байхгүй байна.

Аймаг Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн “Эрчим хүчний үр ашиг” төслөөс 837.2 сая төгрөгийн орлого орж ирснийг ОНХС-ийн дансанд төвлөрүүлэлгүй зарцуулсан байна.

2.2 ОНХС-аар хэрэгжүүлжсэн төсөл арга хэмжээний гүйцэтгэлд тавих хяналт шаардлага хангахгүй, ажлын гүйцэтгэлийг хянаж баталгаажуулалгүй санхүүжилтийг олгож байна.

Аймаг болон сумдын ОНХС-д 2015 онд эхний үлдэгдлээс 737,0 сая төгрөг, ОНХ-ийн нэгдсэн сангаас орлогын шилжүүлгээр 4006,8 сая төгрөг, бусад эх үүсвэрээс 355,2 сая төгрөг, нийт 4362,0 сая төгрөгийн эх үүсвэртэй, 4487,1 сая төгрөгийн зарлагатай ажилласан байна.

ОНХС-ийн хөрөнгө оруулалтын зарцуулалтыг авч үзэхэд дараах зөрчил дутагдал илэрлээ.

Орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалт

Завхан аймгийн ОНХС-ийн аудитаар сумдад илэрсэн зөрчил /сая.төг/

№	Аймаг, нийслэл, сум, дүүргийн нэр	Нийт илэрсэн зөрчлийн дүн /сая.төг/	Зөрчлийн утга									
			Зориулалт бусаар зарцуулсан	Иргэдийн саналаар дэмжигдээгүй ажлыг жагсаалтад оруулж, санхүүжилсэн	Худалдан авах ажиллагааны журам зөрчсөн	Дутуу буюу чанаргүй хийгдсэн, хугацаа хэтэрсэн	Бүртгэл тайланд тусгаагүй	ТЭЗУ, зураг төсөв нь батлаг-даагүй	төсөвт өртөгөөс илүү санхүү-жүүлсэн	Орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдаагүй	Хэрэгжээгүй, санхүүжилтээ аваад ажлаа хийгээгүй	Захиалаг -чийн хяналт тавиагүй
1	Алдархаан	8.00				2.00			2.00		4.00	
2	Асгат	35.80				2.30	31.50				2.00	
3	Баянтэс сум	6.20				1.90	4.30					
4	Баянхайрхан	7.50									7.50	
5	Дөрвөлжин	24.3		24.3								
6	Завханмандал	1.60		1.60								
7	Идэр	10.00	10.00									
8	Их-Уул	24.7	1.60	11.1			12.00					
9	Нөмрөг	19.10		15.10			4.00					
10	Сантмаргаз	13.60									13.60	
11	Түдэвтэй	3.40	3.40									
12	Улиастай	175.50	17.40		35.00	99.40	12.00					11.70
13	Тэлмэн	22.40	5.10	5.30				12.00				
14	Шилүүстэй	4.00	4.00									
15	Яруу	6.20	6.20									
16	Сонгино	7.2	2.2	2.80								2.20
17	Эрдэнэхайрхан	52.40		19.30		29.10		4.00				
18	Ургамал	85.9	36.10	18.60		26.30						4.90
19	Тосонцэнгэл	32.30	21.0	8.7		0.9			0.7			1.00
20	Отгон	46.8	19.10	13.50				12.0	2.20			
21	Цагаанчулуут	2.00	1.00									1.00
22	Цагаанхайрхан	2.00	2.00									
23	Тэс	15.70				15.70						
24	Цэцэн-Уул	29.10						18.00			8.00	3.10
25	Аймаг	261.8	261.8									
ДҮН		897.7	397.2	113.4	35.00	182.2	69.1	46.0	4.90	0.00	28.0	21.9

ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтан дүгнэлт өгөх нийцлийн аудитаар илэрсэн зөрчлийг графикаар харуулбал:

Орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалт



❖ Дээрхи хүснэгтээс харахад нийт зөрчлийн 44 хувь буюу 397,2 сая төгрөгийг зориулалт бус зарцуулсан байна.

Аймаг Сангийн сайдын 2014 оны 43-р тушаалын 4 дэх заалтуудыг зөрчин ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжих боломжтой чиг үүргүүдэд хамаарахгүй дараах төсөл арга хэмжээг санхүүжүүлсэн байна. Үүнд:

- Алслагдсан бүс нутгийн малчдын харилцаа холбооны сүлжээг сайжруулах буюу Завханмандал сумын Бага хайрханы отрын бүс нутаг, Отгон сумын Буянт баг, Баянтэс сумын Зайгал багуудад “Жи мобайл” үүрэн телефоны сүлжээ оруулах ажилд 120.0 сая төгрөгийг,



- "Эрүүл мэнд-Эрс шинэчлэл" хөтөлбөрийн үргэлжлэл нэрээр аймгийн нэгдсэн эмнэлэгт 25.5 сая төгрөгийг, Эрүүл мэндийн газарт 3.8 сая төгрөгийг, Түдэвтэй, Шилүүстэй сумдад эх барих эмчийг тогтвор сууршилтай ажлуулахад тэтгэмж олгон 10.0 сая төгрөгийг, Эрүүл мэндийн олимпиад зохион байгуулж 0.5 сая төгрөгийг,

Орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалт

- "Зөв Завхан Хүүхэд" дэд хөтөлбөрийн үргэлжлэл нэрээр аймгийн Боловсрол соёлын газарт эрх шилжүүлэн 15 төрлийн ажилд 32.4 сая төгрөгийг,
- Зөв амьдрах ухааныг дэлгэрүүлэх, соён гэгээрүүлэх Засаг даргын 3 тулгуурт бодлогыг үргэлжлэлд 21.3 сая төгрөгийг,
- Аймгийн бизнес эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжиж, үзэсгэлэн худалдааг зохион байгуулах ажилд 6.6 сая төгрөгийг,
- "Алтан намар-2015" урлаг спортын наадмыг зохион байгуулахад зориулан 10.0 сая төгрөгийг,
- Яргуй-2015 хүүхдийн ардын урлагийн бага наадам зохион байгуулахад 8.0 сая төгрөгийг,
- "Нэг цонх"-ны үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх гэсэн ажлын зориулалтыг өөрчлөн 5.0 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн ,
- Аймгийн "Иргэний танхим"-ын үйл ажиллагааг тогтмолжуулах нэрээр 2 төрийн сургалт зохион байгуулан 10.0 сая төгрөгийг,
- Гамшиг ослын үед тусгай үүрэг гүйцэтгэх бүлэгт дэмжлэг үзүүлэх Зэвсэгт хүчний 325-р ангид 2.0 сая төгрөгийг тус тус зарцуулжээ.

Орон нутгийн давсан орлогоос аймаг 90.0 сая төгрөгийг, нэр бүхий 12 сум 250.0 сая төгрөгийг, бусад эх үүсвэрээс 15.2 сая төгрөгийг журмын дагуу тус тус ОНХС-ийн дансанд төвлөрүүлэн ажилласан байна.

ОНХС-д үндсэн тэнцлийн ашиг болон бусад орлогоос төвлөрүүлсэн хэсгийг зарцуулахдаа иргэдийн санал авч эрэмбэлэгдээгүй, орон нутгийн төлөвлөгөөнд тусгагдаагүй ажлуудад зарцуулсан байна. Үүнд:

- ✓ Дөрвөлжин сум гудамжны гэрэлтүүлгийн гэрлийн төлбөр, олон нийтийн байцаагчийн цалин олгосон, томилолтын зардал гаргасан, татварын өдрүүд тэмдэглэн өнгөрүүлсэн, цагдаа болон багийн эмчийг унаажуулсан, тэтгэмж олгосон, эмчийн сургалтын төлбөр төлсөн зэрэгт 23.3 сая төгрөг,
- ✓ Нөмрөг сум шагнал урамшуулал, тэтгэмж, нэг удаагийн буцалтгүй тусламжид олгосон 6.0 сая төгрөг,
- ✓ Завханмандал сум олон нийтийн байцаагчид цалин олгосон, аж ахуйн материал худалдан авсан, холбооны шугамын газар шорооны ажил хийсэн иргэдэд хоол хүнс худалдан авч өгсөн зэрэгт 1.6 сая төгрөг,
- ✓ Их-Уул сум гудамжны гэрэлтүүлэгний гэрлийн үнэ төлсөн, компьютер худалдан авсан 3.3 сая төгрөг зэрэг байна.

❖ **Дээрх хүснэгтээс харахад нийт зөрчлийн 20.3 хувь буюу 182.2 сая төгрөгийн ажил дутуу хийгдсэн байна. Тухайлбал:**

➤ Улиастай сумын Жаргалант багийн барилгын ажил 2015 оны 11 сарын 09-с

Орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалт

эхлэж 2015 оны 12 сарын 25-н хооронд хийж гүйцэтгэн ашиглалтанд оруулах байсан ч байгалийн хүчин зүйлийн нөлөөллөөс шалтгаалан гэрээг сунгасан байна.

Уг барилгын төсөвт өртөг 290.0 сая төгрөг бөгөөд урьдчилгаа санхүүжилтэнд 184.0 сая төгрөгийг олгожээ.

Аудитын явцад ажлын гүйцэтгэлтэй танилцахад ажил 30 хувьтай, шаардлагатай материалаа татсан байгаа гэсэн тайлбарыг компани удирдлага өглөө.



Ургамал сумын төв талбайн тохижилтын ажил 2015 оны 09 сарын 24-нөөс өдрөөс 2015 оны 10 сарын 24-ний өдөр хийж дуусган гэрээтэй бөгөөд санхүүжилтийн 70 хувь буюу 18.2 сая төгрөгийг олгосон ажил эхлэл төдий, шаардлага хангахгүй байна.



Чанаргүй, дутуу хийгдсэн ажлуудаас дурьдвал: Эрдэнэхайрхан сумын хөв цөөрөм байгуулах 15.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй усны урсгал тогтоох далан барих ажил шаардлагын хэмжээнд хүрч хийгдээгүй байна.



2015 оны ОНХС-ийн санхүүжилтийн үлдэгдэл 12 дугаар сарын 15-25-ны хооронд орж ирсэн байна. Гүйцэтгэгчтэй ажил эхлэх улирлыг харгалзалгүй гэрээ хийн

Орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалт

урьдчилгааг олгосон, захиалагч ажлын гүйцэтгэлд үндэслэн санхүүжилтийг олгодоггүйгээс дээрх дутагдал гарч байна.


Санхүүжилтийг урьдчилан олгосноор төсвийн мөнгө хууль бус зарцуулагдах, эргэлтэнд орж, үрэгдэх, ажил чанаргүй хийгдэх эрсдлийг дагуулж байна.

Аймгийн ОНХС-аас сумдын ОНХС-д олгох орлогын санхүүжилтийг дулааны улиралд багтаан бүрэн олгодог байх шаардлагатай байна гэж үзлээ.

❖ **Иргэдийн санал авч эрэмбэлэгдээгүй ажил санхүүжүүлсэн дутагдал нийт зөрчлийн 12.6 хувь буюу 113.4 сая төгрөгийг эзэлж байна.**

Иргэдийн санал авч эрэмбэлэгдээгүй томоохон ажлуудаас дурьдвал:

➤ Эрдэнэхайрхан сум 18.2 сая төгрөгийн өртөгтэй бялдаржуулах тоног төхөөрөмж бэлтгэн, сумын төсөвт байгууллагуудад тараан байрлуулсан байна.



➤ Их-Уул сум эрчүүдийн төлөө эрийн гурван наадам нэртэй 10.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажил хэрэгжүүлэн бөхийн зодог шуудаг, цоллоочийн малгай, морь цоллуулах хүүхдийн өмд, цамц, малгай, уралдаанч хүүхдийн дугаар, нум сум зэрэг худалдан авсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 60.3.6 /“Орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал арга хэмжээ санхүүжүүлэхгүй байх”, Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан “ОНХС-ийн заавар”-ын 4.2 “тухайн орон нутгийн иргэдийн саналыг авч журмын дагуу эрэмбэлэгдсэн байх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Дээрхи зөрчил нь ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ажлыг төлөвлөхдөө иргэдийн оролцоог бүрэн хангаагүй, иргэд саналаа ирүүлэхдээ зөвхөн тухайн хэсэг бүлэг хүмүүсийн хэрэгцээ шаардлагад нийцсэн, хэрэгжүүлэхэд үр дүн муутай санал ирүүлдэг зэрэгтэй холбоотой байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалт

Аудитаар цаашид иргэдийн оролцоог ханган ажиллахдаа иргэдээс өөрсдөөс нь санал гаргуулдаг биш, бодлого тодорхойлогчдоос гаргасан саналыг иргэдээр хэлэлцүүлэн эрэмбэлэн хэрэгжүүлдэг байх гэсэн саналыг ихэнх сумд гаргаж байлаа.

Аймаг, сумдын засаг даргын захирамжаар үнэлгээний хороо байгуулан худалдан авах үйл ажиллагааг журмын дагуу зохион байгуулан хэвшсэн байна.

Худалдан авах ажиллагааны журам зөрчсөн 35.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Улиастай сумын усан оргилуур, ногоон байгууламж, явган хүний зам талбай бүхий байгууламж барих ажлыг 2 хэсэг болгон олон нийтийн оролцоотой худалдан авах аргаар сонгон шалгаруулалт явуулан иргэдийн бүлгээр гүйцэтгүүлсэн байна.



Ажлын хэсэг болон үнэлгээний хорооноос гаргасан зөвлөмжийг үндэслэн гүйцэтгэгчтэй гэрээг байгуулсан байна.

Гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний заалтуудыг ажлын онцлогт тохируулан хийдэггүй, ажлын чанар, гэрээг хэрхэн дүгнэх, захиалагч болон гүйцэтгэгчидэд хариуцлага тооцох нөхцлүүдийг тодорхой тусгаагүй гол төлөв нэг загварын гэрээ байгаад цаашид анхаар ажиллах шаардлагатай байна.

Аймаг, сумдын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжсэн 9 төсөл арга хэмжээний үе шатны хяналтыг аймгийн ГХБХГ хэрэгжүүлж, гүйцэтгэлд үндэслэн санхүүжүүлсэн байна.

Сумдын ОНХС-аар хэрэгжүүлжсэн төсөл арга хэмжээнд хяналт тавих ИТХ-ын дэргэдэх Хяналтын хороо, болон иргэд, иргэний нийгмийн байгууллагуудыг томилоогүй, ажлын үе шатаар хяналт тавьсан ажлын тайлан, холбоотой талуудын тайлбар байхгүй байна.

Захиалагч гэрээг дүгнэсэн, хугацааны зөрүүд алданги тооцож хуулийн дагуу хариуцлага ногдуулаагүй байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалт

Энэ нь сумдад олгох санхүүжилт батлагдсан хуваарь, хэмжээний дагуу хугацаандаа олгогдоогүй, гүйцэтгэх ажлын явц, чанарт тавих хяналт сул, гэрээт хугацаандаа дуусгах шаардлагыг захиалагч байгууллагууд хангалтгүй зэрэгтэй холбоотой алданги тооцох боломжгүй байна.

Нэгдсэн сангаас хуваарилагдсан орлогын шилжүүлэг дутуу ирсэнтэй холбоотой сумдад олгох орлогын шилжүүлэг дутуу олгодсон байна.

д/д	Сумдын нэр	АИТХ-аас баталсан /тодотгол/	Сумдын ОНХС-д олгосон санхүүжилт	Зөрүү	Хувь
1	Алдархаан	92.5	60.0	32.5	35.1
2	Баянтэс сум	108.2	88.0	20.2	18.7
3	Баянхайрхан	74.3	50.0	24.3	32.7
4	Дөрвөлжин	90.0	70.0	20.0	22.2
5	Завханмандал	65.1	65.0	0.1	0.2
6	Идэр	107.8	95.0	12.8	11.9
7	Их-Уул	164.3	136.3	28.0	17.1
8	Нөмрөг	79.9	85.0	-5.1	-6.4
9	Түдэвтэй	92.9	95.0	-7.1	0.0
10	Сантмаргаз сум	75.5	50.0	25.5	33.9
11	Улиастай	655.2	500.5	154.7	23.6
12	Асгат	53.3	45.0	8.3	15.6
13	Тосонцэнгэл	254.1	55.0	199.1	78.4
14	Сонгино	89.9	78.0	11.9	13.24
15	Тэс	137.3	130.0	7.3	5.3
16	Тэлмэн	126.5	126.5	0.0	0.0
17	Ургамал	71.0	55.0	16.0	22.5
18	Цагаанхайрхан	67.7	65.0	2.7	4.0
19	Цагаанчулуут	73.4	70.5	2.9	4.0
20	Цэцэн-Уул	93.0	55.0	38.0	40.9
21	Шилүүстэй	88.3	86.7	1.6	1.8
22	Эрдэнэхайрхан	72.3	65.0	7.3	10.1
23	Яруу	67.4	45.0	22.4	33.2
24	Отгон	97.0	75.0	22.0	22.7
	Сумдын дүн	2896.9	2246.5	650.4	

Батлагдсан төсвийг сумдад хуваарилахдаа харьцангуй ялгаатай буюу Завханмандал, Нөмрөг, Түдэвтэй, Тэс, Тэлмэн, Ургамал, Цагаанхайрхан, Цагаанчулуут, Шилүүстэй, Эрдэнэхайрхан зэрэг 10 суманд санхүүжилтийг 90-100 хувь, Алдархаан,

Баянхайрхан, Сантмаргаз, Тосонцэнгэл, Цэцэн-Уул, Яруу зэрэг 6 суманд 21.6-67.3 хувийн санхүүжилт олгожээ.

2.3 Сангийн хөрөнгөөр нийлүүдэгдсэн тоног төхөөрөмжүүдийг данс бүртгэлд бүрэн тусгаагүй байна

ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажил үйлчилгээг эрх бүхий комиссын актаар хүлээн авч байгаа хэдий ч нийлүүлэгдсэн тоног төхөөрөмжийг комиссын актаар хүлээн авах асуудал хангалтгүй байна.

Аудитаар дутуу нийлүүлэгдсэн хөрөнгөтэй холбоотой 2.2 сая төгрөгийн зөрчил илэрлээ.

Асгат, Баянтэс, Их-уул, Нөмрөг, Улиастай сумд нийт 63,8 сая төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй нь НББ-ийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 **/Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккрузал сууриар хөтөлнө/**, Сангийн сайдын 20014 он 43 тоот тушаалаар батлагдсан ОНХС-ийн зааварын 8.6 **/ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтыг орон нутгийн өмчид бүртгэнэ/** гэсэн заалтуудыг зөрчсөнд албан шаардлага хүргүүлэн ажиллалаа.

Зорилт 3. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулж, олон нийтэд ил тод мэдээлээгүй байна.

3.1 ОНХС-ийн хөрөнгийн төлөвлөлт, хэрэгжилтийн байдалд тавих хяналт хангалтгүй байна.

Тайлант оны орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлт, гүйцэтгэлд хяналт тавьж ажилласан байгууллага, иргэний бүлгээс хяналт хийсэн ажлын тайланг шат, шатны Засаг даргын зөвлөлөөр хэлэлцүүлж засаж залруулах арга хэмжээ авч ажилаагүй байгаа нь Сангийн сайдын 2014 оны 43 тоот тушаалаар батлагдсан “ОНХС-ийн заавар”-ын 9.6 **/ОНХС-ийн санхүүжилтээр хэрэгжих хөтөлбөр, төсөл арга хэмжээнд Орон нутгийн дотоод аудитын болон иргэдийн хөндлөнгийн хяналт тавина, орон нутгийн иргэдийн хөндлөнгийн хяналтын тайланг дотоод аудитын тайлангийн хамт Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж холбогдох шийдвэр залруулга арга хэмжээг авна/** гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна.

3.2 Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг байршуулан ажилласан байна.

Аудитын явцад сумдад ажиллахад 2016 онд ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх ажлын жагсаалт, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг ихэнх сумд ил тодын мэдээллийн самбарт байршуулсан боловч, 2015 оны ОНХС-ийн гүйцэтгэлийг болон бусад мэдээллийг мэдээллээгүй байгаад цаашид анхаарч ажиллах зөвлөмжийг хүргүүлэн ажиллалаа.

2016 оны 1 дүгээр улирлын байдлаар ОНХС-гийн төлөвлөгөө, гүйцэтгэлийг 18 нэгж, байгууллага буюу 72 хувь нь мэдээлж, 7 байгууллага буюу 28 хувь нь мэдээллээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.5.3. /Төсвийн гүйцэтгэл, зарцуулалт нь батлагдсан төлөвлөгөөний дагуу хэрэгжиж байгаа эсэхэд олон нийт хяналт тавих боломжоор хангах/ , 6.5.4. /төрөөс үзүүлж байгаа аливаа ажил, үйлчилгээ, хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, тэдгээрийн хүрээнд худалдан авч байгаа бараа, ажил, үйлчилгээнд олон нийт хяналт тавих боломжоор хангах/ Засгийн газрын 2012 оны 17 дугаар тогтоолоор батлагдсан “төсөв санхүүгийн ил тод байдлыг хангахад дагаж мөрдөх журам”-ын 5.2./Цахим хуудас болон мэдээллийн бусад хэрэгсэл ашиглаж байгаагаас үл хамааран төсвийн байгууллага мэдээллийн самбарыг заавал ажиллуулна/ гэсэн заалттай нийцэхгүй байна

Байгууллагууд мэдээллийн самбартаа ОНХС-тай холбоотой мэдээллүүдийг төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангахад дагаж мөрдөх журмын хавсралтаар батлагдсан маягтын дагуу байршуулан, олон нийтэд мэдээлж хэвшээгүй байна.

3.3 Өмнөх оны аудитаар өгөгдсөн акт, албан шаардлага, зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй байна

ОНХС-ийн 2014 оны хөрөнгийн орлого бүрдүүлэлт, зарцуулалт, хэрэгжилтийн байдалд дүгнэлт өгөх аудитаар Аймгийн ИТХуралд 2 заалт, Аймгийн засаг даргад 11 заалт, сумдын засаг дарга нарт 8 заалт бүхий зөвлөмжийг хүргүүлэн ажилласнаас 9 сум буюу 37.5 хувь нь хэрэгжүүлэн ажилласан байна.

Өгөгдсөн зөвлөмж, албан шаардлагыг биелүүлээгүй 15 сумын засаг дарга нарт хуулийн дагуу хариуцлага тооцуулахаар шийдвэрлэлээ.

Орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалт

Өмнөх оны аудитаар 15 Албан шаардлага өгч, 55.9 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоосноос 13 албан шаардлагыг хэрэгжүүлэн, 33.0 сая төгрөгийн төлбөрийн актыг барагдуулан ажилласан байна.

Аудитаар 829.2 сая төгрөгийн зөрчлийг илрүүлж, 68.5 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоогдлоо.



ОНХС-аар хэрэгжүүлжсэн төсөл арга хэмжээний гүйцэтгэлд тавих хяналт шаардлага хангахгүй, ажлын гүйцэтгэлийг хянаж баталгаажуулалгүйгээр санхүүжилтийг олгож байна.

ДАРГА
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Л.УЛАМБАЯР



Орон нутгийн хөгжлийн сангийн 2015 оны хөрөнгийн орлого бүрдүүлэлт, зарцуулалт, хэрэгжилтийн байдал, хууль тогоомжинд нийцсэн эсэхэд хийсэн нийцлийн аудитын дүн дүгнэлтэнд үндэслэн дараах зөвлөмжийг хүргүүлж байна.

Аймгийн Засаг дарга Ж.Жамъянтив танаа

1. Аймгийн ОНХС-д татварын хувь хэмжээг нэмэгдүүлсэн орлого болон төсвийн зарлагын бодит хэмнэлт, дотоод, гадаадын хандив, тусламжын орлогын тооцоо судалгааг үндэслэн гаргаж 2017 оны төсвийн төсөлд тусгах
2. Хөтөлбөр нэрээр ажлыг жижиглэн байгууллагын үйл ажиллагааг дэмжих, хөрөнгө бэлтгэх ажлыг төлөвлөгөөнд тусгаж, батлуулдаггүй байх
3. Орлогын шилжүүлэгийг олгохдоо сумдад батлдагдсан дүнгээс ижил хувиар тооцон олгож байх
4. Ажлын гүйцэтгэлийг бүрэн хянаж санхүүжилтийг олгож байх
5. Дуусаагүй төсөл арга хэмжээний судалгааг сум бүрээр гарган, хэрэгжилтийг хангуулах
6. Бүх шатны хяналт, мониторинг хийгдсэн ажлын дүгнэлт тайланг Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж холбогдох шийдвэр гарган хэрэгжүүлж ажиллах

Сумдын засаг дарга нарт

1. Иргэдийн төлөөлөгчдийн хурлаараа тооцоо судалгаа, зураг, төсөвтэй хэрэгжих боломжтой, үр дүнг бодитой тооцсон ажлуудыг хэлэлцүүлэн батлуулж байх
2. Сангийн дансанд төвлөрсөн орон нутгийн давсан орлогыг журмын дагуу эрэмбэлэгдсэн төсөл арга хэмжээнд зарцуулж байх
3. Ажлын гүйцэтгэлийг бүрэн хянаж санхүүжилтийг олгож байх
4. Дуусаагүй төсөл арга хэмжээний судалгааг нарийвчлан гаргаж дүгнэлт хийх
5. Ил тодын мэдээллийн самбарт ОНХС-ийн мэдээллийг байршуулан олон нийтэд нээлттэй мэдээллэх
6. Бүх шатны хяналт, мониторинг хийгдсэн ажлын дүгнэлт тайланг Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж холбогдох шийдвэр гарган хэрэгжүүлж ажиллах



Аймгийн засаг дарга Ж.Жамъянтив танаа

- ОНХС-ийн заавар журамд тусгагдаагүй төсөл арга хэмжээг төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлдэг явдлыг таслан зогсоох
- Эрүүл мэнд эрс шинэчлэл хөтөлбөрийн тайланг аудитын газар тогтоосон хугацаанд ирүүлэх
- Дээрхи алдаа зөрчлүүдийг жил бүр давтан гаргаж өгсөн албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлэн ажлаагүй Асгат, Дөрвөлжин, Их-Уул, Нөмрөг, Отгон, Түдэвтэй, Тэлмэн, Тосонцэнгэл, Улиастай, Ургамал, Цагаанчулуут, Цэцэн-Уул, Шилүүстэй, Эрдэнэхайрхан сумдын засаг дарга нарт холбогдох хуулийн дагуу хариуцлага тооцох
- ОНХС-ийн хөрөнгийн санхүүжилтийг сумдад хуваарийн дагуу жигд олгох

Алдархаан сумын засаг дарга А.Мөнхсайхан-д

- Ажлын гүйцэтгэл дутуу, санхүүжилтээ бүрэн авсан гудамжны гэрэлтүүлгийн засварын 2000,0 мянган төгрөгийн, Доной цогцолборын тохижилтын 4000,0 мянган төгрөгийн ажлуудыг бүрэн гүйцэтгүүлэн, гэрээг дүгнэж, хяналт тавьж ажиллах
- Баяр наадмын арга хэмжээнд зориулан төсвөөс зарцуулах зардлын жишиг дээд хэмжээг баримтлан ажиллах

Асгат сумын засаг дарга Г.Баярсайхан-д

- Архивын байрны засвар тохижилтын 2000,0 мянган төгрөгийн, цаг уурын тоног төхөөрөмжийн засварын 1800,0 мянган төгрөгийн, гудамж талбайн хаягжуулалтын 500,0 мянган төгрөгийн ажлуудын гүйцэтгэгчтэй гэрээг сунган байгуулж, дутуу ажлыг гүйцэтгүүлэн, гэрээг дүгнэж, хяналт тавьж ажиллах
- ОНХС-ийн хөрөнгөөр бэлтгэгдсэн халуун усны барилга, гал түймрийн тоног төхөөрөмжийг данс бүртгэлд тусгах

Баянтэс сумын засаг дарга Ч.Бямбадорж-д

- ОНХС-ийн хөрөнгөөр бэлтгэгдсэн багийн төвийн тохижилтийн 2000,0 мянган төгрөгийн, иргэний танхим тохижуулах 2287,8 мянган төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлд тусгах

Баянхайрхан сумын засаг дарга Г.Гантөмөр-т

- ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх худаг засварын 7500,0 мянган төгрөгийн ажлыг бүрэн гүйцэтгүүлэн, гэрээг дүгнэж, хяналт тавьж ажиллах

Их-Уул сумын засаг дарга Д.Баясгалан-д

- Малын үйлдвэр угсааг сайжруулах зорилгоор худалдан авсан 13000,0 мянган төгрөгийн эцэг малыг данс бүртгэлд тусгах
- Гэрэлтүүлгийн зардлыг орон нутгийн төсөвт тусган батлуулах

Нөмрөг сумын засаг дарга Ж.Нанзаддорж-д

- Иргэний танхим тохижуулах зориулалтаар авсан 4000,0 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг данс бүртгэлд тусгах

Отгон сумын засаг дарга Ж.Амгаланбаяр-т

- Соёл багийн засварын ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, гэрээний хугацаанд хэрэгжүүлэн данс бүртгэлд тусгах
- Журамд тусгагдсан чиг үүргүүдийн дагуу иргэдээс санал авч эрэмбэлэгдсэн төсөл хөтөлбөр арга хэмжээг төлөвлөх, зарцуулах хөрөнгө, төсөвт өртгийг нарийн тооцоолон ажиллах.

Сантмаргаз сумын засаг дарга Ц.Энх-Амгалан-д

- ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх Цэцэрлэгийн гадна хайс, төв талбайн хайс хийх 13600,0 мянган төгрөгийн ажлуудыг бүрэн гүйцэтгүүлэн, гэрээг дүгнэж, хяналт тавьж ажиллах

Сонгино сумын засаг дарга Д.Дандаабаяр-т

- Журамд тусгагдсан чиг үүргүүдийн дагуу иргэдээс санал авч, эрэмбэлэгдсэн төсөл хөтөлбөр арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлэх .

Тосонцэнгэл сумын засаг дарга Б.Төрмөнх-д

- Журамд тусгагдсан чиг үүргүүдийн дагуу иргэдээс санал авч, эрэмбэлэгдсэн төсөл хөтөлбөр арга хэмжээг төлөвлөх, зарцуулах хөрөнгө, төсөвт өртгийг нарийн тооцоолон ажиллах.

- Урьд онд гүйцэтгэл хийгдсэн бөгөөд санхүүжилт дутуу арга хэмжээ, төсөл хөтөлбөрийг тухайн оны төсөвт тусган хэрэгжүүлэх
- ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх төсөл хөтөлбөр арга хэмжээний төсөл зургийн үнийг тус сангаас зарцуулах

Тэс сумын засаг дарга Ж.Мөнхцэцэг-т

- Лед гэрлүүдийг угсарч суурилуулах ажлыг бүрэн гүйцэтгүүлэн, гэрээг дүгнэж, хяналт тавьж ажиллах

Тэлмэн сумын засаг дарга А.Даваадорж-д

- Журамд тусгагдсан чиг үүргүүдийн дагуу иргэдээс санал авч эрэмбэлэгдсэн төсөл хөтөлбөр арга хэмжээг төлөвлөх, зарцуулах хөрөнгө, төсөвт өртгийг нарийн тооцоолон ажиллах.

Улиастай сумын засаг дарга Д.Энх-Амгалан-д

- Жаргалан багийн барилгын ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, гэрээний хугацаанд хэрэгжүүлэн данс бүртгэлд тусган ажиллах
- ОНХС-ийн хөрөнгөөр бэлтгэгдсэн хөрөнгийг данс бүртгэлд тусгах
- Намчинмамба өрхийн ЭМТ-ийн дансаар дамжуулан бэлтгэсэн хөрөнгийг холбогдох байгууллагын данс бүртгэлд тусгуулах арга хэмжээ авч ажиллах
- Усан оргилуур, ногоон байгууламж, явган хүний зам талбай, чулуун хашаа бүхий байгууламжийг хүлээн авч, данс бүртгэлд тусгах
- Модон гүүрний усан оргилуурын ажлыг гүйцэтгүүлэн хүлээн авч, ашиглалтанд оруулах

Ургамал сумын засаг дарга С.Очирбал-д

- Төв талбайн тохижилтийн дутуу ажлыг гүйцэтгүүлэн, гэрээг дүгнэж, хяналт тавьж ажиллах
- Эвдэгдсэн газрыг нөхөн сэргээх 4900,0 мянган төгрөгийн ажлын гүйцэтгэлийн дутуу материалыг нөхөн гүйцээх
- Журамд тусгагдсан чиг үүргүүдийн дагуу иргэдээс санал авч эрэмбэлэгдсэн төсөл хөтөлбөр арга хэмжээг төлөвлөх, зарцуулах хөрөнгө, төсөвт өртгийг нарийн тооцоолон ажиллах.
- 2014 онд гүйцэтгэл хийгдсэн бөгөөд санхүүжилт дутуу арга хэмжээ, төсөл хөтөлбөрийг тухайн оны төсөвт тусган хэрэгжүүлэх

Цагаанчулуут сумын засаг дарга Г.Цэрэнханд-д

- Сумын төвийн хайсжуулах ажлын дутууг гүйцээх, Арц багийн худгийн ажлыг бүрэн гүйцэтгүүлж гэрээг дүгнэж, хяналт тавьж ажиллах

Цэцэн-Уул сумын засаг дарга Б.Оргилсайхан-д


- Биеийн тамирын талбай тохижуулах, онцгой байдлын арга хэмжээнд тоног төхөөрөмж бэлтгэх, Шотой багийн засварын ажлуудыг гэрээний дагуу гүйцэтгэж, гэрээг дүгнэж, хяналт тавьж ажиллах
- Иргэдийн санал авч эрэмбэлэгдсэн ажлуудын ТЭЗҮ-ийг үнэн зөв хийж, төсөвт өртгийн урьдчилсан тооцоо судалгааг хийж, төсвийн төлөвлөгөөг бодит төлөвлөх

Эрдэнэхайрхан сумын засаг дарга О.Чулуунбаатар-т

- Гүйцэтгэгчтэй гэрээг сунган байгуулж, дутуу ажлыг гүйцэтгүүлэн, гэрээг дүгнэж, хяналт тавьж ажиллах
- Хөв цөөрөм байгуулах ажил гүйцэтгэсэн Цагаанхайрхан бүлгийн үлдэгдэл санхүүжилтийг олгохгүй байх
- Байгууллагын гадна хаягийг гэрээний дагуу гүйцэтгүүлж, үлдэгдэл санхүүжилтийг үнийн саналыг харгалзан олгох,
- Урьд онд гүйцэтгэл хийгдсэн дутуу санхүүжилттэй арга хэмжээ, төсөл хөтөлбөрийг тухайн оны төсөвт тусган хэрэгжүүлэх

Яруу сумын засаг дарга О.Энхбат-д

- Журманд тусгагдсан чиг үүргүүдийн дагуу иргэдээс санал авч, зохих журмын дагуу эрэмбэлэгдсэн төсөл хөтөлбөр арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлэх
- ТГ-ын урсгал болон хөрөнгийн зардлыг санхүүжүүлэхийг таслан зогсоох



Дөрвөлжин сумын засаг дарга Н.Батболд-д

- Зориулалт бус зарцуулсан 1,086,770 /нэг сая наян зургаан мянга долоон зуун дал/ төгрөгийг Аймгийн төрийн сангийн 090000955 тоот дансанд төвлөрүүлж, 2016 оны 06 дүгээр сарын 15- ны дотор хариу ирүүлэхийг Дөрвөлжин сумын засаг дарга /Н.Батболд/, Санхүүгийн албаны дарга /Т.Байгаль/ нарт хариуцуулав

Идэр сумын засаг дарга Ч.Мөнххүрэл-д

- Зориулалт бус зарцуулсан 10,000,000 /арван сая/ төгрөгийг Идэр сумын ОНХС сангийн дансанд төвлөрүүлж, 2016 оны 05 дугаар сарын 15-ны дотор хариу ирүүлэхийг Идэр сумын Засаг дарга /Ч.Мөнххүрэл/, Санхүүгийн албаны дарга /Т.Сэлэнгэ/ нарт хариуцуулав.

Нөмрөг сумын засаг дарга Ж.Нанзаддорж-д

- Зориулалт бус зарцуулсан 5,950,000 /таван сая есөн зуун тавин мянган/ төгрөгийг Нөмрөг сумын ОНХС-ийн дансанд төвлөрүүлж, 2016 оны 06 дугаар сарын 15-ны дотор хариу ирүүлэхийг Нөмрөг сумын Засаг дарга /Ж.Нанзаддорж/, Санхүүгийн албаны дарга /С.Цэнд-Аюуш/ нарт хариуцуулав.

Сонгино сумын засаг дарга Д.Дандаабаяр-т

- Зориулалт бус зарцуулсан 2,200,000 /хоёр сая хоёр зуун мянган/ төгрөгийг Сонгино сумын ОНХС-ийн дансанд төвлөрүүлж, 2016 оны 06 дугаар сарын 15-ны дотор хариу ирүүлэхийг Сонгино сумын Засаг дарга /Д.Дандаабаяр/, Санхүүгийн албаны дарга /н.Баянмөнх/ нарт хариуцуулав.

Тосонцэнгэл сумын засаг дарга Б.Төрмөнх-д

- Эх үүсвэр давхардуулан олгосон 1,000,000 /нэг сая / төгрөгийг Аймгийн орон нутгийн орлогын 090000955 тоот дансанд, зориулалт бусаар зарцуулсан 700,000 төгрөгийг Тосонцэнгэл сумын ОНХС-ийн дансанд төвлөрүүлж, 2016 оны 06 дугаар сарын 15-ны дотор хариу ирүүлэхийг Тосонцэнгэл сумын Засаг дарга /Б.Төрмөнх/, Санхүүгийн албаны дарга /Ц.Лхагвасүрэн/ нарт хариуцуулав.

Түдэвтэй сумын засаг дарга Д.Төртогтох-д

- Зориулалт бус зарцуулсан 2,705,100 /хоёр сая долоон зуун таван мянга нэг зуун/ төгрөгийг Түдэвтэй сумын ОНХС-ийн дансанд төвлөрүүлж, 2016 оны 06 дугаар сарын 15-ны дотор хариу ирүүлэхийг Түдэвтэй сумын Засаг дарга /Д.Төртогтох/, Санхүүгийн албаны дарга /В.Дорж/ нарт хариуцуулав.

Улиастай сумын засаг дарга Д.Энх-Амгалан-д

- Зориулалт бусаар зарцуулсан 4,667,000 /Дөрвөн сая зургаан зуун жаран долоон мянган/ төгрөгийг Улиастай сумын ОНХС-ийн дансанд төвлөрүүлж, 2016 оны 06 дугаар сарын 15-ны дотор хариу ирүүлэхийг Улиастай сумын Засаг дарга

Орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалт

/Д.Энх-Амгалан/, Тамгын газрын дарга /Д.Сандагдорж/ Төрийн сангийн төлөөлөгч /Я.Дэлгэрмаа/ нарт хариуцуулав.

Ургамал сумын засаг дарга С.Очирбал-д

- Зориулалт бусаар зарцуулсан 36,100,000 /гучин зургаан сая нэг зуун мянга/ төгрөгийг Ургамал сумын төрийн сангийн 091152400 тоот дансанд төвлөрүүлж, 2016 оны 05 дүгээр сарын 15-ны дотор хариу ирүүлэхийг Ургамал сумын Засаг дарга /С.Очирбал/, Санхүүгийн албаны дарга /О.Сугарбаяр/ нарт хариуцуулав

Цагаанчулуут сумын засаг дарга Г.Цэрэнханд-д

- Зориулалт бус зарцуулсан 1,000,000 /нэг сая / төгрөгийг Аймгийн орон нутгийн орлогын 090000955 тоот дансанд төвлөрүүлж, 2016 оны 06 дугаар сарын 15-ны дотор хариу ирүүлэхийг Цагаанчулуут сумын Засаг дарга /Г.Цэрэнханд/, Санхүүгийн албаны дарга /Э.Ганчимэг/ нарт хариуцуулав.

Цэцэн-Уул сумын засаг дарга Б.Оргилсайхан-д

- Зориулалт бус зарцуулсан 3,147,500 /гурван сая нэг зуун дөчин долоон мянга таван зуун / төгрөгийг Цэцэн-Уул сумын ОНХС-ийн дансанд төвлөрүүлж, 2016 оны 06 дугаар сарын 15-ны дотор хариу ирүүлэхийг Цэцэн-Уул сумын Засаг дарга /Б.Оргилсайхан/, Санхүүгийн албаны дарга /М.Ичинхорлоо/ нарт хариуцуулав.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Л.УЛАМБАЯР

Холбогдох байгууллагын санал



ЗАВХАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

212800 Улиастай, Завхан аймаг,
Утас: (01-462) 2-24-54, 2-10-13

2016. 04. 29 № 6/402

танай _____-ны № _____-т

АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Санал хүргүүлэх тухай

Тус газрын 2015 оны ОНХС-н хөрөнгийн зарцуулалтын тайлантай танилцлаа. Тайлангийн зарим нэг дүгнэлттэй санал нийлэхгүй байна. Үүнд:

1.Аймгийн Засаг дарга ОНХС-н хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төслийн урьдчилсан жагсаалтыг гарган баг, хорооны хурал, иргэний танхимаар хэлэлцүүлээгүй байна гэсэнтэй санал нийлэхгүй байна. Учир нь 2015 оны ОНХС-н хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төслийн урьдчилсан жагсаалтыг гарган бүх сум руу албан тоот хүргүүлэн хариу авсан ба Улиастай сумын багуудын хурал дээр очиж санал авахуулах ажлыг багийн дарга нартай хамтран зохион байгуулсан. Энэхүү ажлыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн Б.Туяа гардан гүйцэтгэсэн.

2.Гадаад тусламжийн орлогыг ОНХС-д төвлөрүүлээгүй зарцуулжээ гэдэгтэй санал нийлэхгүй байна. Швейцарын хөрөнгө оруулалтаар ГОУХАН-ийн хэрэгжүүлж буй "Эрчим хүчний үр ашгийн төсөл" нь Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу байгуулагдсан хөрөнгө оруулалтын төсөл тул түүгээр хэрэгжсэн төсөл арга хэмжээ нь гадаад тусламжийн орлого гэж үзэхгүй бөгөөд улс хоорондын хэлэлцээрийн дагуу эрх зүй нь зохицуулагддаг. Иймд хамтран хэрэгжүүлэх гэж төсөл арга хэмжээнд харилцан 2 талаас хөрөнгө тусгаж, тусгай данс нээн байршуулан нийлээд нарийн хяналтын доор зарцуулагддаг билээ. Иймд олон улсын гэрээ хэлэлцэлийн дагуу явагддаг үйл ажиллагаа тул танай байгууллагын дээрх дүгнэлттэй санал нийлэхгүй байна.

3.Аймаг Сангийн сайдын 2014 оны 43-р тушаалын 4 дэхь заалтуудыг зөрчин ОНХС-н хөрөнгөөр хэрэгжих боломжтой чиг үүргүүдэд хамаарахгүй дараах төсөл арга хэмжээг санхүүжүүлсэн байна гэсний Алслагдсан бүс нутгийн малчдын харилцаа холбооны сүлжээг сайжруулах гэдэгтэй санал нийлэхгүй байна. Учир нь Төсвийн тухай хуулийн 60.3-т заасан ОНХС-аас зарцуулах хориглосон зүйлд ороогүй. Сүүлийн 2 жил дараалан орон нутгийн иргэдийн эрэмбэлэгдсэн саналуудын хамгийн ихээр авсан саналуудын нэг байсан зэргээс шалтгаалан дээрх дүгнэлттэй санал нийлэхгүй байна.

Албан тоот-2016

Орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалт

Мөн түүнчлэн аймгийн бизнес эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжиж, үзэсгэлэн худалдааг зохион байгуулах ажилд зарцуулсан гэдэг нь Төсвийн тухай хуулийн 60.3-т заасан ОНХС-аас зарцуулах хориглосон зүйлд ороогүй учраас ОНХС-аас санхүүжих боломжтой гэж үзсэн.

ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА



Д.БАТ-УНДРАА

Аймгийн Засаг даргаас ирүүлсэн саналуудыг аудитын дүгнэлт тайланд тусгасан байдал

Орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалтанд хийсэн аудитын дүгнэлт тайланг аймгийн Засаг даргад хүргүүлэн санал авч ажиллаа. Энэ саналд:

1.ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, төслийн урьдчилсан жагсаалтыг гарган баг, хорооны хурал, иргэний танхимаар хэлэлцүүлээгүй гэсэнтэй санал нийлэхгүй байна.

Энэ саналын талаар дахин тодруулахад аймгийн хөгжлийн бодлогын хэлтэсээс аймагт ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, төслийн урьдчилсан жагсаалтыг гарган сумуудад албан тоотоор хүргүүлэн ажилласан байна.

Аймгийн хөгжлийн бодлогын хэлтэс Улиастай сумын 6 багтай хамран, сумын иргэдэд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, төслийн урьдчилсан жагсаалтыг тараан санал авсан, иргэд нийтийн хурлаар хэлэлцүүлсэн хурлын тэмдэглэл, хурлын шийдвэр, саналыг эрэмбэлж нэгтгэсэн жагсаалт нөхөн ирүүлсэн байсан тул энэ саналын талаар аудитын дүгнэлт тайланд залрууллага хийгдсэн болно.

2.Гадаад тусламжийн орлогыг ОНХС-д төвлөрүүлэлгүй зарцуулсан гэдэгтэй санал нийлэхгүй байна.

Аймагт Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн “Эрчим хүчний үр ашиг” төслөөс 837,2 сая төгрөг олгон 3 суманд хөрөнгө оруулалтын ажил хийгдсэн бөгөөд уг мөнгийг данс нээн байршуулж хөрөнгө оруулалтанд зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2 ОНХС-ын нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ 60.2.5 /тухайн орон нутгийн хөгжлийн дэмжих зорилгоор олгосон дотоод гадаадын хандив тусгамж/ гэсэн заалтыг зөрчсөн тул аудитын тайланд залрууллага хийгдээгүй болно.

3.Алслагдсан бүс нутгийн малчдын харилцаа холбооны сүлжээг сайжруулах буюу Завханмандал сумын Бага хайрханы отрын бүс нутаг, Отгон сумын Буянт баг, Баянтэс сумын Зайгал багуудад хийгдсэн ажлууд, Аймгийн бизнес эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжиж, үзэсгэлэн худалдааг зохион байгуулах ажилд зарцуулсан хөрөнгийг Төсвийн тухай хуулийн 60,3-т заасан ОНХС-ийн зарцуулахыг хориглосон заалтанд ороогүй тул хүлээн зөвшөөрөхгүй байна.

Энэ төсөл арга хэмжээ нь ОНХС-ийн зааварын 4.5/ орон нутгийн төсвийн бүс байгууллагуудад ОНХС-аас хөрөнгө зарцуулахгүй байх/, гэсэн заалтыг зөрчсөн ТБОНӨХБАҮХА тухай хуулийг зөрчин тендер шалгаруулалгүй хувийн аж ахуйн нэгжийг санхүүжүүлсэн тул аудитын дүгнэлт тайланд залрууллага хийгдээгүй болно.

Ахлах аудитор
Аудитор
Аудитор

Д.Оюунжаргал
Б.Жалбаа
Ч.Бямбасүрэн